




“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Бидний 2020 нд дэвшүүлсэн зорилт

- ☑ Хувьцааг эзэмшигчийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, ашигт ажиллагааг хангах
- ☑ Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг эхлүүлэх
- ☑ Компанийн тогтвортой хөгжлийг хангах, дотоод зохион байгуулалт, засаглалыг сайжруулах



Концесын гэрээ, “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг 2020 оны 7, 10 дугаар сард эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан.

**Засгийн газрын 2020 оны
227 дугаар тогтоол**

/Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4.11, Концессын гэрээний 17.3.1 заалтыг үндэслэн КОВИД-19 цар захлын нөхцөл байдлыг харгалзан УБХОУНОШБ-ын үйл ажиллагааг 2020-10-01-ний өдрийн дотор эхлүүлэх арга хэмжээ авахыг ЗТХЯ, ҮХГ, ИНЕГ-т даалгасан.

**Засгийн газрын 2020 оны
134 дугаар тогтоол**

“Үйл ажиллагаа эхлэх хугацааг хойшлуулах тухай” Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 227 дугаар тогтоолын “2020 оны 10 дугаар сарын 01-ний” гэснийг “2021 оны 07 дугаар сарын 01-ний” гэж өөрчилсүгэй.

“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК, “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК нь 2020 оны 11 дүгээр сараас тусгай горимд шилжсэн.

**49 хувийн хөрөнгө
оруулалт**

**“НУБИЭ” ХХК-д бүрэн
шилжүүлж, гэрээгээр
хүлээсэн үүргээ
биелүүлсэн.**

2020.11.01

2021.07.01

2020.10.01

2020.07.01




Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах “Чингис хаан” Олон улсын шинэ нисэх буудалд хүчтэй аадар бороо, мөндөр орж, үер буусны улмаас 13 объектийн 49 цэгт инженерингийн байгууламжид үүссэн эвдрэл, гэмтэлийн нөхөн олговор 828 сая төгрөгийг “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК нь “Монгол даатгал”-аас гаргууллаа.





Эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх “Сонгино” дэд станц 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад орж, Олон улсын шинэ нисэх онгоцны буудлын цахилгаан хангамж үндсэн тэжээлээс холбогдлоо.

ТӨРИЙН ХҮНДЭТ ЗОЧНЫ ТАНХИМ

Монгол Улсын сайд, Засгийн хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад харилцааны сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 33/ А/24/ А/101 дугаар тушаалаар “Чингис Хаан олон улсын нисэх буудлын Төрийн хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх журам”-ыг шинэчлэн батлуулж, “Хүндэт зочны танхим”-ийн үйл ажиллагааг эрхлэхэд шаардагдах техник, хэрэгсэл, холбогдох тусгай зөвшөөрлийг Төв аймгийн мэргэжлийн байгууллагуудаас авч, үйл ажиллагаа эхлэх бэлтгэлийг бүрэн хангаад байна.



Е-MONGOLIA төслийн хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас нэвтрүүлсэн “Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем”-ийг 2020 оны 11 дүгээр сараас эхлэн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлээд байна.



Компанийн төсөв, зардлыг хэмнэх, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, цахим хэлбэрт шилжүүлсэн.

САНХҮҮГИЙН БАЙДАЛ



➤ 45 хувийн хэмнэлттэй ажилласан.

➤ Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн тайланд Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын тайлангаар “Зөрчилгүй” гэсэн дүгнэлт авсан болно.

➤ Тэвчиж болох бүх зардлыг зогсоосон.